



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.23 № 06/267

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ашигт малтмал, газрын тосны газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлүүд нь бидний тогтоосон 3,349,420.2 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийлбэр дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхүйц байна. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн 13,856,504.3 мянган төгрөгийн хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөртэй холбоотой авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй;
- Бараа материалын нөөц дансанд бүртгэлтэй 23,175,390.3 мянган төгрөгийн өртөгтэй улсын нөөцийн шатахууныг өнөөгийн бодит өртгөөр (үнэ цэнээр) дахин үнэлж бүртгэлд тусгаагүй;
- Шатахууны нөөц, борлуулалт, тооцооны бүртгэлтэй холбоотой 9,821,992.9 мянган төгрөгийн авлага, өглөгийг санхүүгийн тайландаа бүртгээгүй;
- Авлагын дансны бүртгэл, баталгаажуулалт хангалтгүйгээс 8,109,827.4 мянган төгрөгийн үлдэгдэл бодитой эсэх нь нотлогдоогүй;

- Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа 8,884,034.3 мянган төгрөгийн дансны үнэ бүхий хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй байна.

Эдгээр зөрчил нь санхүүгийн тайланд өргөн тархаагүй боловч Төсвийн тухай хуулийн 6, 16 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан шаардлагад нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, оршин байх, үнэлгээ, ангилал ба толилуулгын батламж мэдэгдлийг хангаагүй байна.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 34 дүгээр тогтоолоор иргэний агаарын тээврийн тогтвортой үйл ажиллагааг хангах, агаарын хөлгийн түлшний хомсдол, тасалдал үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг сэлгэн хадгалах гэрээ”-ний дагуу аж ахуйн нэгжүүдэд хадгалагдаж байгаа зуны дизель түлшний нөөцөөс 5,191.6 тонн түлшийг зах зээлийн үнээр зээлээр худалдан борлуулж, уг борлуулалтын орлогоор агаарын хөлгийн “ТС-1” түлшний улсын нөөцийг бүрдүүлэхээр шийдвэрлэсэн бөгөөд тус шийдвэрийн дагуу “Эрчис-Ойл” ТӨХХК-д холбогдох үүргийг өгч, тайлант хугацаанд 6 компанийн хадгалалтад байсан нийт 3,506.8 тонн дизель түлшийг хүлээн авч, 9,821,992.9 мянган төгрөгийн борлуулалт хийсэн байна.

### **Аудитын гол асуудал**

Хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр олгох сонгон шалгаруулалтыг 2025 онд 18 удаа зохион байгуулж, нийт 1.0 сая га бүхий 269 талбайгаас 573.5 мянган га талбайд хамаарах 128 тусгай зөвшөөрөл олгож, улсын төсөвт 137,895,940.8 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 5 дахин давуулан биелүүлсэн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Монгол Улсад нүүрсний давхаргын метан хийн хэвтээ өрөмдлөгийг анх удаа хэрэгжүүлж, туршилтын олборлолтыг эхлүүлсэн байна. Тодруулбал, “Метан Газ” ХХК нь Redlake-001-3b-Hz-01 болон Redlake-001-3b-Hz-02 цооногуудад 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр хэвтээ өрөмдлөгийн туршилтын ажлыг эхлүүлж, 2025 оны 08 дугаар сарын 18-ны өдрөөс метан хий ялгарч эхэлсэн бөгөөд тайлант хугацааны эцсийн байдлаар тогтвортой хийн гарцтай байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ